

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-6
	1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	3-6

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 15-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан;
Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан.

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг;

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.МӨНХБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР
/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг ирье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Л.Мөнхбаатар ирсэн, Э.Бат-Амгалан ирсэн, С.Бямбацогт ирсэн, Б.Дэлгэрсайхан гишүүн чөлөөтэй, Ц.Мөнх-Оргил гишүүн ирсэн, Ц.Мөнхцэцэг гишүүн ирсэн, Ш.Раднаасэд гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Ж.Сүхбаатар гишүүн ирсэн, Н.Учрал гишүүн ирсэн, Д.Цогтбаатар гишүүн ирсэн, Б.Энхбаяр гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал хэлэлцэнэ. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн тогтоолыг товч танилцуулъя. Та бүгдэд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг Үндсэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Мөнхбаатар -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ц.Мөнх-Оргил -Улсын Их Хурлын гишүүн
Д.Цогтбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Сандаг-Очир -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Мөнхцэцэг -Улсын Их Хурлын гишүүн
Б.Энхбаяр -Улсын Их Хурлын гишүүн

нарын бүрэлдэхүүнтэй байгуулж байна.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

М.Үнэнбат -Хууль эрх зүйн газрын байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ч.Хосбаяр -Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимийн тэргүүн

Б.Батцэрэн -Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч

Д.Эрдэнэбалсүрэн -Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч

М.Чинбат -Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх

Ч.Батбямба	-Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх
П.Сайнзориг	-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
О.Мөнхбаатар	-Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор
Д.Цолмон	-Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга
С.Гантулга	-Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа
Х.Эрдэм-Ундрах	-Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Б.Батзориг	-Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч, доктор, дэд профессор
Ш.Цолмон	-Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч
П.Хулан	-Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт

нарын бүрэлдэхүүнтэй байгуулж байна.

З.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Л.Мөнхбаатар зөвшөөрсүгэй гэсэн байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. Гишүүд ээ. /алх цохив/

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД